

НИЙТЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

**МОСКВАД БОЛСОН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БАГА ХУРАЛ**

ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгээс эрхлэн Москва хотноо 1982 оны 4-р сарын 5-наас 7-нд «БНХАУ-ын төрийн байгуулалт ба нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлууд» хэмээх сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохиов. Бага хуралд БНБАУ, БНАГУ, БНУАУ, БНПАУ, БНМАУ, Вьетнам, Куба, ЗСБНХУ, БНСЧСУ-ын олон улсын харилцааны хятадыг судлагч эрдэмтэд мэргэжилтэн нар болон эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургуулийн эрдэмтэд оролцож хятадын дотоод байдал, нийгэм эдийн засгийн хөгжил, түүний хэтийн төлөвийн талаар олон илтгэл тавьж хэлэлцүүлэв. ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн захирал. ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн М. И. Сладковскийн «БНХАУ-ын нийгэм эдийн засгийн амьдралын зарим хандлага», БНАГУ-ын д-р Хелмут Петерсын «Хятадын удирдагчдын өөрчлөлт, зохицуулалтын бодлого, үйлдвэрлэлийн хэрэгслийг нийгэм хэрхэн өмчлөж байгаа болон түүний хөгжилт», БНУАУ-ын Олон улсын харилцааны хүрээлэнгийн захирал, д-р Барна Талашийн «Хятадын зохицуулалтын асуудлууд, Өөрчлөлт ба шинэчлэлт», ЗХУ-ын ШУА-ийн Олон улсын ажилчны хөдөлгөөний хүрээлэнгийн профессор Ю. Т. Гельбрасын «БНХАУ-ын төрийн байгууллын нийгэм-эдийн засгийн үндэс», Вьетнамын төлөөлөгч Хонг Лонгын «Дөрвөн шинэчлэл, нийгэм эдийн засгийн зөрчил» зэрэг илтгэлүүд эрдэмтэд, мэргэжилтэн нарын сонирхлыг ихэд татав.

Бага хуралд тавьсан илтгэлүүдэд БНХАУ-ын одоогийн засаг төрийн байгуулалт ба нийгэм эдийн засгийн байдлыг тал бүрээс нь нарийвчлан задлан шинжлэж тодорхой үнэлэлт өгснөөс гадна эрдэмтэд хэлэлцсэн асуудлуудаар санал бодлоо өргөн солилцов.

Бага хурал ЗХУКН-ын XXVI их хурал, ах дүү намуудын их хурлын заалтууд болон ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Л. И. Брежневийн 1982 оны 3-р сард Ташкентэд хэлсэн үгийн үзэл санааг мөрдлөг болгож, БНХАУ-ын хөгжил ба түүний үйл ажиллагааны нарийн түвэгтэй асуудлуудыг авч үзээд: БНХАУ-ын улс төр, эдийн засгийн үндэс, түүний үүргийн хувьсал, улс төрийн системд арми, олон нийтийн байгууллагуудын эзлэх байр суурь улс төрийн байгуулал болон нийгэм эдийн засгийн хувьслын хэтийн төлөв хандлага, сүүлийн жилүүдэд хятадын нийгмийн амьдралд зөрчилтэй өөрчлөлтүүд гарч бай- на гэсэн гол санаа дүгнэлтүүдийг илтгэлдээ тодорхой тусгажээ. Тус хурал БНХАУ-ын одоогийн удирдагчид гадаад дотоод бодлогодоо Мао Зэдуны заасан чиг шугамыг баримталж байгааг тэмдэглээд олон улсын тгвцан дээр хятадын эрх баригчид энэхүү чиг шугамаа, идэвхжүүлж империализм ба харгис хүчинтэй сүлбээлдэх явдлаа улам өргөтгөж байна гэсэн дүгнэлтийг хийлээ. БНХАУ-ын засаг захиргааны байгуулалт ба нийгэм-эдийн засгийн одоогийн байдал түүний хөгжлийн хэтийн төлөвийн талаар сүүлийн үед Хятадад болж буй үйл явдалтай холбогдуулж урьдчилсан гол гол дүгнэлт хийсэнд хурлын ач холбогдол оршино.

А. Дамдинсүрэн